



АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИД ХУРАЛДЛАА



Аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн 2015 оны 10-р сарын 09-ний өдрийн хуралдаанаар дараах 4 асуудал хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд: 1. Газрийн харилцааны мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, иргэн ААНБайгууллагын газар өмчлөх, эзэмшүүлэх үйл явц дахь өргөдөл гаргахаас

эхлээд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх үе шат хүртэлх бүхий л үйл явцыг нээлттэй ил тод болгох, мэдээллийн чанар, аюулгүй байдлыг бүрэн хангасан програм хангамж нэвтрүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг дэмжиж тогтоол гаргалаа.

2. Аймгийн орон нутгийн төсвийн орлого зарлагын гүйцэтгэл, нэгдсэн төсвийн татаас шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, Ч.Энхбаяр, Татварын хэлтсийн дарга Н.Түмэннасан, болон холбогдох мэргэжилтнүүд танилцуулга, мэдээлэл хийв. Одоогийн байдлаар аймгийн төсвийн орлого 521,1 сая төгрөгөөр тасарч байна. Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэхэд үүрэгтэй оролцдог байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, төлөвлөгөө гарган ажиллахыг ИТХ-ийн тэргүүлэгчдээс үүрэг болгов.

3. Орон нутгийн өмчийн асуудлаар дараах шийдвэр гарав.

а) Малчин сумын ахлах сургуулийн хуучин дотуур байрны барилгыг дуудлага худалдаагаар худалдах, Дуудлага худалдааны доод үнэ 44,0 сая төгрөг

б) Өндөрхангай сумын ЗДТГ-ын хог тээвэрлэх авто машин дуудлага худалдаагаар худалдах, Дуудлага худалдааны доод үнэ 8,4 сая төгрөг

с) Завхан сумын хуучин наадмын талбайн барилга хашааг саравчны барилгыг сумын өмч хамгаалах зөвлөлөөр үнэлгээ тогтоон худалдах, хашааг цэцэрлэг, сургуульд балансаас балансад шилжүүлэхээр тус тус шийдвэрлэв

4) Шагналд тодорхойлох тухай. Монгол улсын гавьяат цолтонд 2, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонд 2, Алтангасад одонд 11, Хөдөлмөрийн хүндэт медальд 11 хүнийг тус тус тодорхойлж ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлэв.

"УЛААНГОМ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ"-ИЙН ОЮУТНУУДЫН ДАДЛАГЫН ЯВЦТАЙ ТАНИЛЦЛАА.



2015 оны 10 дугаар сарын 15-ны өдөр "Улаангом политехник коллеж"-ийн удирдах зөвлөлийн дарга Ч.Чимэд, "Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн дарга Б.Цэцээ нар "Улаангом политехник коллеж"-ийн оюутануудтай дадлага хийж буй газар нь очиж дадлагын явц болон

Мэргэжлийн боловсрол сургалтын төвийг төгссөн оюутнууд ажлын байран дээр гараад гологдож байна, юм хийж чадахгүй байна гэсэн гомдлууд ажил олгогчдын зүгээс их ирдэг болсны дагуу тэдгээр оюутнуудыг дадлагын талбай дээр очиж дадлагаа чанартай бүрэн гүйцэт, таслахгүй хийж чадаж байна уу?, дадлагын удирдагч багш нар нь юу хийдэг?, дадлагыг хийхэд ямар асуудал тулгарч байна вэ? зэрэг олон асуудлын хүрээнд харилцан ярилцлаа. Мөн "Улаангом политехник коллеж"-ийн удирдлага болон багш нартай дээрх асуудлын талаар харилцан ярилцаж оюутнуудын дадлага хэрхэн хийгдсэн, явал ажлын байран дээр гараад гологдохгүй мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж гаргах талаар харилцан ярилцлаа. Энэ хичээлийн жилд 11 ангийн нийт 384 оюутан танилцах, үйлдвэрлэлийн, төгсөлтийн өмнөх дадлага хийсэн байна.



ИРГЭНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙГ ЦАГ АЛДАЛГҮЙ ХИЙЖ БАЙХ НЬ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ИРГЭНД ХҮРГЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ САЙНААР НӨЛӨӨЛНӨ.



Одоогийн байдлаар Иргэний бүртгэлээр Улаангом сумын 27 мянган хүн оршин сууж байгаа гэсэн бүртгэлтэй боловч шилжилт хөдөлгөөний бүртгэл хийгдээгүй нийт иргэдийг оруулж тооцвал 31,000 гаруй иргэд оршин сууж байна гэсэн мэдээлэл байна. Энэ нь оршин сууж байгаа хүн амын тоонд тулгуурлан ирэх оны төсөв төлөвлөгөө боловсруулах, төрөөс үзүүлэх бүх төрийн үйлчилгээнд хүндрэл учрах нөхцөл байдал бий болж байгаа юм. Дээрх нөхцөл байдлыг үндэслэн Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, аймгийн засаг даргын орлогч Б.Цэцээ, ТЗУХ-ын дарга, Д.Баяраа, Статистикийн хэлтсийн дарга Ж.Эрдэнэсүрэн Улаангом сумын засаг дарга О.Ганхуяг, Улаангом сумын иргэний бүртгэлийн мэргэжилтэн Даваа, УБХэлтсийн мэргэжилтэн Амгаланнамжил нар шуурхай хуралдаан зохион байгуулж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярилцаж дараах арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөв.

МААМУУГИЙН БАТЦЭНД ТОЙРГИЙНХОО АРД ИРГЭДИЙН ДУНД "АЛТАН НАМАР-2015" УРГАЦЫН БАЯРЫГ ХИЙЛЭЭ.



Улаангом сумын 1-р баг буюу Чандманиас аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон Маамуугийн Батцэнд 10 сарын 16-ны

билэгт сайн өдөр тойргийнхоо ард иргэдийн дунд "Алтан намар-2015" ургацын баярыг хийлээ. Энэ үеэр Төрийн дээд шагнал болон аймаг орон нутгийн шагналаар шагнагдсан хүмүүсийн шагнал болон ургацын баярыг тохиолдуулан зохион байгуулсан спортын тэмцээний шагналыг гардуулж өнгөрсөн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа танилцуулан цаашид тойрогтоо хийхээр бодож, төлөвлөсөн ажилаа сонгогчиддоо танилцуулсан юм.

"ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗАМААР БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ" СЭДЭВТ БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖЕРҮҮДИЙН ЗӨВЛӨГӨӨН

Газрын харилцаа, геодизе зураг зүйн газар, Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон-Алт төсөл, Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Аймгийн ҮХААГазар, Аймгийн ГХБХБГ, Аймгийн бэлчээр ашиглалтын холбооноос 2015 оны 10 сарын 22-23-ны өдрүүдэд дээрх зөвлөгөөнийг зохион байгууллаа. Энэ зөвлөгөөний зорилго нь:

1. Бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт, цаашдын хандлагын талаар судалгааны дүнгээс танилцуулах
2. Бэлчээрийг зохистой ашиглах талаар аймаг, орон нутгийн түвшинд дорвитой өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагын талаар нэгдсэн ойлголтод хүрэх
3. 2016 онд аймаг, сумдын түвшинд бэлчээрийн менежмент, МАА-н үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлох
4. Бэлчээрийн менежментэд оролцогч талуудыг татан оролцуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг эрчимжүүлэхэд оршино.



“ГАМШГИЙН АЮУЛЫГ ТООЦЪЁ, ЭРТЛЭН ТӨЛӨВЛӨӨ, ЭРСДЭЛГҮЙ ДАВЪЯ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАА.

Мерси Кор Монгол ОУБ-аас хэрэгжүүлж буй LTS-2 төслийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан “Гамшгийн аюулыг тооцъё, эртлэн төлөвлөө, эрсдэлгүй давъя” сэдэвт



сургагч багш бэлтгэх баруун бүсийн сургалтыг Увс аймгийн Улаангом хотод 9.21-нээс 9 сарын 23-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж дууслаа. Сургалтанд баруун бүсийн Увс, Ховд, Баян-Өлгий аймгаас нийт 53 хүн оролцож, эдгээр 53 оролцогчийн 48 сургагч багшаар бэлтгэгдэн сургагч багшийн сертификатыг гардаж авлаа. Гурван өдөр үргэлжилсэн тус сургалтаар зудын гамшгийн үед хэрхэн ажиллах, эрсдлээ хэрхэн тооцох, эрсдлийн үнэлгээ хийх аргачлалыг сургагч багш нарт эзэмшүүлж гамшгийн эрсдэл, эмзэг байдлын талаарх ерөнхий ойлголттой болгох, гамшгаас урьдчилан сэргийлэх арга, гамшгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, бүтэц, гамшгийн бэлэн байдал, түүнийг хангахад чиглэсэн мэдлэгийг олгосон юм. Эдгээр мэдлэгийг эзэмшсэн сургагч багш нар өөрийн сумын иргэдийн төлөөлөлд гамшгийн мэдээ, мэдээллийг шуурхай байдлаар хүргэх, байгаль цаг уурын эрсдлийг тооцох, түүнийг эрсдэлгүй даван туулах чадварыг эзэмшүүлнэ.

УВС АЙМАГ МЭДЛЭГТ СУУРИЛСАН ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ



Бүртгэл мэдээллийн системийн алдаа, мэргэжилтнүүдийн хариуцлагагүй байдал зэрэг олон шалтгааны улмаас нэг газрыг хэд хэдэн хүнд давхардуулан олгох, бэлчээр, газрын маргаан тасралтгүй гарч байдаг. Газрын харилцааны энэхүү хоцрогдсон байдлыг арилгах, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, газар зохион байгуулалт, төлөвлөлтийг судалгаанд суурилан боловсруулах бодлогыг Увс аймаг 2012 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хүрээнд Увс аймгийн ИТХурал, Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас Газрын харилцаа, Геодези, зураг зүйн газартай хамтран ажиллаж, орон нутгийнхаа гео орон зайн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлээд байна. Дээрх мэдээллийн санг ашиглан орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлон төлөвлөхөд ихээхэн ач холбогдолтой юм. Тиймээс гео орон зайн мэдээллийг хэрхэн ашиглах, хэрэглээг сайжруулах зорилготой “Гео орон зайн мэдээллийг орон нутгийн хөгжилд ашиглах нь” сэдэвт бага хурлыг Газрын харилцаа, Геодези зураг зүйн газраас орон нутагтай хамтран зохион байгуулж байна. Газар төлөвлөлтийн бодлогыг олон нийт газар өмчлөх, кадастрын зургаар баталгаажуулах төдий л ойлгож, хэрэглэж ирсэн. Харин газрын харилцааг хөгжлийн суурь болгон авч үзэж, шинжлэх ухааны үндэстэй, мэдлэгт суурилсан хөгжлийн бодлого тодорхойлох ажлуудыг Монгол улсад анх удаа Увс аймаг хэрэгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлж эхэлж байгаа нь энэ юм.

САГИЛ СУМ:

ОНӨ-ийн талаарх арга зүйн сургалт боллоо.

Увс аймгийн Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2015 оны 10-р сарын 10-аас 11-р сарын 05-ны хооронд Орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах сарын аяныг зохион байгуулж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулан сумын бүхий л төсөвт байгууллагуудын өмчид хяналтын тооллого хийсэн байна.



Энэ хяналтын тооллогоор илэрсэн зөрчил дутагдалын арилгалт цаашид ОНӨ-ийг ашиглалт, хадгалалалт, хамгаалалтыг сайжруулахаар Сагил сумын ИТХ, Өмч хамгаалах

зөвлөл, ЗДТГ, Сургууль, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын байгууллагуудын өмч хамгаалах зөвлөлийг оролцуулан төрийн болон орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах хадгалах, хамгаалах арга зүйн талаар сургалт зохион байгууллаа.

ӨНДӨРХАНГАЙ СУМ:

1. Хяналт үнэлгээний ажил.

Гал тогоо бүхий байгууллагууд Цэцэрлэг, хүн эмнэлэг, ахлах сургуулийн дотуур байрны гал тогооны үйл ажиллагаанд хүний хөгжил нийгмийн асуудлын хороо, ЗДТГ-тай хамтран хяналт хийж хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авлаа. Үдийн цай



хөтөлбөрийн хэрэгжилтэнд төсөв, санхүү, эдийн засгийн хороо хяналт хийж үдийн цай хөтөлбөрийн бүтээгдэхүүн нийлүүлж байгаа ААН-үүд, анги танхим, бэлтгэж байгаа газруудыг үзэж зөвлөмж чиглэл, даалгавар өглөө.



2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагаа. Дотуур байрны сурагчдад хүмүүжил төлөвшил олгох зорилгоор ИТХ-ын дарга Л. Ичинхорлоо, тэргүүлэгч Х.Дэмбэрэлсамбуу, А. Даваажаргал нар 1 оройг



хүүхдүүдтэй хамт өнгөрөөж сургамжтай үг өгч хэлэлцүүлэг хийж санал бодлыг нь сонсож амьдралын түвшин доогуур 2 хүүхдэд гарын бэлэг, 2 хүүхдийг азтанаар шалгаруулж мөн гарын бэлэг гардууллаа.

3. Бусад ажил. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан ААН, иргэдээр хяналт шалгалтын ажил хийж хяналт шалгалтын дүн, цаашид анхаарах асуудлаар ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

www.facebook.com/groups/uvs.ith

